



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/198

Мандалговь

Зураг төсөв хүлээн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журамын 4.3.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Олгойн говид 2, 3-р өргөх насос станцын дунд хийгдсэн байгаа 3.5км дан цэвэр усны шугамыг хос шугам болгох ажлын зураг төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

С.Ариунжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд:

Э.Энхмэнд (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Б.Буманбаатар (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга:

Д.Сэргэлэнбаатар (Дундговь-Ус орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын инженер)
М.Баярмаа (Мөнх консалтинг ХХК-ийн инженер)

2. Зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (С.Ариунжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100634